

**“БОГД БАНК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЭРДЭНЭ ОВОГТОЙ БЯМБАЖАВЫН 2024 ОНЫ 3-Р УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН”**

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, ТУЗ-н дэргэдэх Аудитын хорооны даргаар болон эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн тухай хууль, банкны тухай хууль, Богд банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

НЭГ. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хуралд оролцсон тоо: 21

Хэлэлцсэн асуудал: 26

2024 оны 3 дугаар улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн 21 хуралд цахимаар болон танхимаар оролцож хурлаар хэлэлцсэн 26 асуудлаар саналаа хурлын тэмдэглэлд товч бичиж, хурлын шийдвэрт тусгуулан ажилласан. Хэлэлцсэн асуудлаар 20 гаруй санал хэлсний 80% нь шийдвэрт туссан болно.

ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН ХОРОО

Нийт хуралдсан тоо: 1

Хэлэлцсэн асуудал: 2

2024 оны 3 дугаар улиралд Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн..

2024 оны 3-р улирал

| | | | |
|---|------------|-------|--|
| 1 | 2024.07.04 | 24/03 | 1.Богд банкны 2024 оны 2 дугаар улирлын эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийн тайлан 2.Богд банкны 2024 оны 2 дугаар улирлын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан |
|---|------------|-------|--|

ГУРАВ .СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Мөн хугацаанд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 2 удаагийн хэлцэлд оролцож өөрийн саналыг өгч, сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэж ажилласан.

2024 оны 3-р улирал

| | | | |
|---|------------|--------|----------------------------------|
| 1 | 2024.07.09 | 24/89 | Б.Уламбаярт машин худалдах тухай |
| 2 | 2024.09.11 | 24/109 | Богд системс-д зээл олгох тухай |

ДӨРӨВ.ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ХУВЬД:

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно гэж үзнэ. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох чөлөөлөх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2024 оны 3 улирлын товч тайланг бэлдэн хүргүүлэв.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2024.10.10

Э.Бямбажав.